

Нацагийн Батболд[✉], Төмөрбаатарын Түвшинжаргал¹
Жамсранжавын Баярсайхан¹, Дамчаабадгарын Содномжамц¹

¹Шинжлэх ухааны академийн Археологийн хүрээлэн,
Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайваны өргөн чөлөө,
Шинжлэх ухааны Академийн хүрээлэнгүүдийн нэгдсэн 1 байр

Мөнххайрханы соёлын судалгааны тойм ба сүүлийн үеийн үр дүн

Хураангуй. Монгол болон хил залгаа бүс нутагт хүрлийн дунд үеийн төгсгөл болон хүрлийн хожуу үед (НТӨ 1500-700) хүн ам, соёлын томоохон идэвхжилт бий болсон байдаг. Энэхүү үйл явцад эс-чулууны үеийн Афанасьев (НТӨ 3000-2500), хүрлийн түрүү үеийн Хэмцэг (НТӨ 2500-1800), хүрлийн дунд үеийн эхэнд хамаарах Мөнххайрхан (НТӨ 1900-1600) зэрэг соёлууд хэрхэн оролцсон хийгээд угсаа гарвал, соёлын ямар хамааралтай вэ гэдэг асуудал нарийвчлан шийдвэрлэгдээгүй байна. Энэхүү угсаа соёлын үйл явц бүрэлдэх хийгээд, үйлдвэрлэх аж ахуйн үүсэл хөгжилд Мөнххайрханы соёл нэн чухал үүрэгтэй оролцсон байх магадлалтай. Тиймээс тус соёлын судалгаанд анхаарал хандуулж өдгөө хүртэл хийгдээд буй судалгааны үр дүнг тус өгүүллээр нэгтгэн авч үзэв. Бид 2024 онд Увс аймгийн нутгаас 4 булш илрүүлэн олж, 1 булш малтан судалсан бол Хөвсгөл аймгийн нутагт 2007 онд 1, 2017 онд 2 булш тус бүр малтан судалж энэхүү соёлын судалгаанд зохих хувь нэмэр оруулжээ. Нийт тоон мэдээллийг нэгтгэн үзвэл одоогоор Монгол улсын хэмжээнд Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан, Хөвсгөл, Булган, Архангай, Өвөрхангай гэсэн 8 аймгийн нутагт Мөнххайрханы соёлын нийт 24 булш малтан судалсан дүн гарах бөгөөд энэ нь тархцын хүрээг харьцангуй том орон зайд тэлж буй ч дурсгалын тоо цөөн, маш сийрэг тархацтай болохыг харуулна. Тиймээс бидний цаашдын судалгааны зорилго нь Мөнххайрханы соёлын дурсгал руу чиглэсэн хайгуул, малтлага судалгааг дагнан гүйцэтгэж, соёлын тархац хүрээ, нягтралыг тодорхойлох улмаар тухайн соёлын эздийн мэдээлэл, угсаа гарвал, соёлын залгамж холбоо, аж ахуй, нийгэм соёлын асуудлыг тусгайлан авч үзэхэд чиглэгдэнэ.

Түлхүүр үг. Хүрлийн үе, Мөнххайрханы соёл, булш орицуулга, хүрэл хутга, ясан халбага

Batbold Natsag[✉], Tuvshinjargal Tumurbaatar¹,
Bayarsaikhan Jamsranjav¹, Sodnomjamts Damchaabadgar¹

¹Institute of Archaeology,
Mongolian Academy of Sciences Building-1
Peace Avenue, Ulaanbaatar-13330, Mongolia

Overview of Munkhkhairkhan culture research and recent results

Abstract. During the late Middle Bronze Age (ca.1500-1300) and throughout the Late Bronze Age (ca.1300–700 BCE), significant cultural and demographic developments occurred in Mongolia and its surrounding regions. The genetic and cultural impact of many early pastoral cultures, such as the Afanasievo (ca.3000–2500 BCE), the Khemceg (ca 2500–1800 BCE), and the Munkhkhairkhan (ca.1800–1600 BCE) is a key focus of archaeological research. We hypothesize that the Munkhkhairkhan culture played a crucial role in shaping ethnic and cultural processes during the Middle and Late Bronze Ages, as well as in the development of food-producing economies in the Mongolian plateau. According to our review, a total of 24 Munkhkhairkhan culture burials have been excavated across eight aimags, including Bayan-Ulgii, Uvs, Khovd, Khuvsgul, Zavkhan,

Arkhangai, Uvurkhangai, and Bulgan provinces. In 2024, we excavated one burial out of four so far discovered in Uvs aimag, building upon 2007 and 2017 excavations of three such features in Khusgul aimag,. Findings from this research indicate that the Munkhkhairkhan culture was distributed over a relatively large area, but the number of sites is limited and sparsely distributed within this range. Future research will focus on conducting targeted surveys and excavations of Munkhkhairkhan cultural sites to determine their distribution range and density. This will facilitate the clarification of the cultural identity, genetic origins, cultural continuity, and socio-economic aspects of the people associated with this culture.

Keywords. *Bronze Age, Munkhkhairkhan Culture, burial mounds, bronze knife, bone spoon (ladle).*

Судалгааны тойм. Мөнххайрханы соёлын булшийг анх А.А.Ковалев, Д.Эрдэнэбаатар нарын судлаачид 2003 онд Төв Азийн шинжилгээний ангийн хүрээнд Ховд аймгийн Мөнххайрхан сумын нутагт илрүүлэн малтан судалж, тус газрын мөнх цаст уулын нэрээр ийнхүү нэрлэжээ (Erdenebaatar and Kovalev 2003). Тус судалгааны ангийн судлаачид Мөнххайрхан сумын Борт багийн нутаг Дунд цэнхэрийн голын дагуу Мөнххайрханы соёлд хамаарах булшийг анх малтан судалсан ч булшны тоо, газар усны нэр зэргийг орос болон монгол хэлээрх хэвлэлд бага зэрэг зөрүүтэй тэмдэглэсэн байдаг (Erdenebaatar and Kovalev 2003; (Erdenebaatar and Kovalev 2007; Erdenebaatar 2016; Kovalev and Erdenebaatar 2009; Kovalev and Erdenebaatar 2014). Гэсэн хэдий ч А.А.Ковалев, Д.Эрдэнэбаатар нарын судлаачдын 2009, 2014 онуудад орос, англи хэлээр нийтлүүлсэн үнэмлэхүй он цагийн мэдээлэл бүхий өгүүллүүдээс үзвэл Мөнххайрханы соёлд холбогдох нийт 4 булш малтан судалсан бололтой байна. Тухайлбал, Улаан говийн үзүүрийн 1/1 дугаартай, дугуй хэлбэрийн чулуун дараастай булшнаас зүүн хажуугаар нь хэвтүүлэн хөлийг агийлгаж, толгойг зүүн зүгт хандуулан тавьсан оршуулга илэрсэн бөгөөд булшинд ясан халбага, модон бариултай хүрэл шөвөг, модон бариултай хүрэл хутга, модон савх зэрэг олдворыг дагалдуулсан байжээ (Ковалев, Эрдэнэбаатар 2014). Харин Улаан говийн үзүүрийн 2/1, Хатуу даваа 1/1, Артуу¹ зэрэг дугаартай булшнууд эрт цагт тоногдсон байсан (Kovalev and Erdenebaatar 2014) ба зөвхөн Хатуу давааны булшнаас махир хэлбэртэй хүрэл эдлэл илэрч олдсон ажээ (Erdenebaatar and Kovalev 2003, 10; Kovalev and Erdenebaatar 2014, 213; Kovalev and Erdenebaatar 2009, 161). Хатуу даваа болон Хөх толгойн булшнаас гарсан гэх хүрэл эдлэл гар зургийг харьцуулж харахад нэг олдвор бололтой бөгөөд Ковалев Хатуу даваа, харин Д.Эрдэнэбаатар Хөх толгой хэмээн дурсгалт газрыг өөр өөрөөр нэрлэж хэвлүүлсэн бололтой. Мөнххайрхан сумын Хөх толгой гэх тус дурсгалт газарт мөн Сагсай хэлбэрийн булшнууд малтан

судалсан байдаг (Erdenebaatar and Kovalev 2007, 40-41).

Улмаар А.А.Ковалев нарын судлаачид Хөвсгөл, Завхан, Баян-Өлгий зэрэг аймгийн нутагт Мөнххайрханы соёлын булшны судалгааг үргэлжлүүлэн хийсэн. Тухайлбал, 2004 онд Хөвсгөл аймгийн Арбулаг сумын нутаг Галбаагийн үзүүр хэмээх газраас Мөнххайрханы соёлд холбогдох 2 булш илрүүлж, 2006 онд малтан судалжээ. Галбаагийн үзүүрийн 1-р булш нь 30 м голчтой дугуй хэлбэртэй байхын зэрэгцээ булшны дараасны баруун талыг бараан, зүүн талыг цайвар өнгөтэй чулуугаар өрж хийсэн онцлогтой бөгөөд булшнаас эрт цагт тоногдсон хүний оршуулга илэрч ямар нэгэн олдвор хэрэглэгдэхүүн олдоогүй аж (Erdenebaatar and Kovalev 2007, 38; Kovalev and Erdenebaatar 2014, 204, 213). Харин Галбаагийн үзүүрийн 2-р булш нь дугуй булшны зэрэгцээ байрлах бөгөөд 6х6 м дөрвөлжин хэлбэртэй. Тус булшнаас зүүн хажуугаар хэвтүүлж, зүүн хойд зүгт хандуулан оршуулга илэрсний зэрэгцээ хүрэл хутга, хүрэл шөвөг зэрэг олджээ (Kovalev and Erdenebaatar 2014, 204, 213). Мөн онд Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Цагаан уушиг хэмээх газарт 3х3 м, 6х6 м хэмжээтэй 2 булш малтан судалсан байна. Цагаан уушигийн 2-р булш нь маш их тоногдсон ба хүрлийн зэвний ногоон толбо бүхий хүний эрүүний яснаас өөр олдвор илрээгүй аж. Харин Цагаан уушигийн 3-р булшнаас өсвөр насны хүүхдийн ясны хамт дугуй хэлбэртэй, дундаа нүхтэй танан чимэглэл бүтэн 20, хагархай 10 илэрсэн ба тус булшны олдвор болон хүний яс нь тарваганы нүхний шороогоор зөөгдөж гарч ирсэн байжээ (Kovalev and Erdenebaatar 2014, 204-206, 216). Мөн судлаачид 2007 онд Завхан аймгийн Баянтэс сумын нутаг Тэсийн голын эргээс Мөнххайрханы соёлын булшийг илрүүлж малтан судалсан байдаг ба тус дурсгалт газар нь 3 булш болон бусад тахилын байгууламжаас бүрдэх бололтой (Kovalev and Erdenebaatar 2014, 207). Хөх хошууны боомын 1-р булшнаас нурууны яс хөндөөгүй оршуулга илэрсэн хүний цээжин хэсгээс дөрвөлжин хэлбэрийн ясан зүүлтүүд анхны байрлалаараа илэрч олджээ (Kovalev and Erdenebaatar 2014, 212, 214). 2014 онд А.А.Ковалев, Ч.Мөнхбаяр нар хамтарч Баян-Өлгий

1 Монгол хэлээр нийтлүүлсэн судалгааны бүтээлүүдэд тус газрын нэрийн талаар тодорхой дурдсан зүйл байхгүйг учир орос судлаачдын тэмдэглэсэн нэрээр нь ашиглав.

аймгийн Цэнгэл сумын нутаг Шар говийн эхэн хэмээх газарт 43 м голчтой 1 том булш малтсан бөгөөд тус булшинд хүнээ хажуу тийш нь хөмөглөж оршуулсан байсан бөгөөд булшнаас тааран эдлэл дээр сураар хадаж тогтоосон цагариг хэлбэрийн хүрэл олдсон судалгааны маш чухал олдвор байжээ (Kovalev and Munkhbayar 2018). Тус булшийг 2004 онд “Төв Азийн археологийн шинжилгээ” төслийн хүрээнд А.В.Варенов илрүүлсэн болохыг дурдсан байдаг (Erdenebaatar and Kovalev 2007, 38; Kovalev and Munkhbayar 2018, 44).

Эдгээр булшнаас гадна 2006-2014 онд Бүрэнтогтох сумын нутгаас Мөнххайрханы соёлын булш 3-ыг ирүүлсэн тухай дурдсан (Kovalev and Erdenebaatar 2014, 201) ба 2014 онд саяхан тоногдсон 5 м голчтой дугуй хэлбэрийн булшийг шалгасан хэмээсэн нь дээрх 3 булшны нэг бололтой (Kovalev and Erdenebaatar 2014, 205). Тэрээр Ховд, Баян-Өлгий, Завхан, Хөвсгөл гэсэн 4 аймгийн нутагт нийт 14 булш малтан судалсан тухай өгүүлсэн (Kovalev 2017, 58) ба дээрх тоногдсон шалтгаанаас тодорхой дурдаагүй 3 булшийг тооцож үзвэл тэдний малтсан булшны тоо 15 болно. Гэвч зарим булшны тоногдсон байдал, хүний яс, олдвор гараагүй зэрэг шалтгаанаас малтсан булшны тоо бага зэрэг зөрж байж болох тул тэдний нэгтгэн гаргасан тоогоор 14 булш малтсан хэмээн авч үзэв. Ийнхүү А.А.Ковалев, Д.Эрдэнэбаатар нарын судлаачид Мөнххайрханы соёлын дурсгалыг анх нээн ирлүүлж, он цаг, тархцын хүрээг тодорхойлж бие даасан соёл болохыг баталсан чухал ач холбогдолтой судалгааг хийсэн хэмээн дүгнэж болно.

Дээрх судлаачдаас гадна Монголын археологичид сонирхох үүднээс болон авран хамгаалах судалгааны хүрээнд санамсаргүй байдлаар Мөнххайрханы соёлын булшийг малтан судалж эхэлсэн байдаг ба 2007, 2015, 2017, 2019, 2020, 2022, 2024 онуудад нийт 10 булш малтан судалжээ. Тухайлбал, 2007 онд Монгол-Америкийн хамтарсан “Буган хөшөө” төслийн хүрээнд Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Хогорын голд нэгэн булшийг санамсаргүй илрүүлэн малтан судалсан ба булшны бүтэц зохион байгуулалт, оршуулгын зан үйл болон үнэмлэхүй он цагийн судалгаа зэргээр тус булш Мөнххайрханы соёлд холбогдох нь тодорхой болжээ (Bayarsaikhan 2013). Тус булш нь тоногдоогүй байсан ч ямар нэгэн олдвор хэрэглэгдэхүүн илэрч олдоогүй онцлогтой.

2015 онд Эгийн голын усан цахилгаан станцын авран хамгаалах судалгааны явцад Мөнххайрханы соёлын булш 1-ийг малтан судалсан нь одоогоор Булган аймгийн нутгаас илэрч олдоод буй цор ганц булш болж байна. Энэ нь Харуулын гозгорын 1-113 дугаартай булш бөгөөд дугуй хэлбэрийн хавтгай чулуун дараастай тус булшинд нас барагчийг зүүн

хажуугаар нь тавьж, хөлийг өвдгөөр нугалан, зүүн хойд зүгт хандуулан оршуулсан байсан ба хүрэл хутга, хүрэл гархи, хүрэл шөвөг, ясан халбага, ясан булцуу зэрэг баялаг олдвор хэрэглэгдэхүүн дагалдуулжээ (Iderkhangai et al. 2015, 371-375).

2017 онд Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын нутаг Хөгийн голын дагууд Багсагийн булан хэмээх газарт өнгөн хөрснөөс цухуйх төдий мэдэгдэх хавтгай чулуун дараастай дугуй болон дөрвөлжин хэлбэртэй 2 булш малтан судалжээ (Bayarsaikhan et al. 2017). Тус 2 булшны дугуй хэлбэртэй булшнаас ямар нэгэн хүний яс олдвор хэрэглэгдэхүүн илэрч олдоогүй бол дөрвөлжин хэлбэртэй булшнаас хүний эрүүний хэсэг, нэгэн хүрэл цагаригийн хамт илэрч олджээ (Bayarsaikhan et al. 2017). Мөн тус онд Завхан аймгийн Тосонцэнгэл сумаас Сонгино сум чиглэлд тавигдсан засмал замын дагууд хийгдсэн археологийн авран хамгаалах малтлага судалгааны хүрээнд Тэлмэн сумын нутаг Бага Шовх улаан хэмээх газарт 1 булш малтан судалжээ (Amartuvshin et al. 2017). Тус булшны гадаад зохион байгуулалт нь намхан дугуй хэлбэрийн чулуун дараастай байсан бөгөөд малтлагын 1 м орчим гүнээс тоногдож хөндөгдсөн хүний оршуулга илэрчээ. Хүний ястай цуг дөрвөлжин хэлбэртэй нүхтэй ясан чимэглэл 40, хүрэл зүү (шөвөг) 1 тус тус илэрч олджээ (Amartuvshin et al. 2017). Тус булшнаас илэрсэн ясан чимэглэл нь А.А.Ковалев, Д.Эрдэнэбаатар нарын судлаачдын Завхан аймгийн Баянтэс сумын Хөх хошууны боомын булшнаас илрүүлж олсон зүүлттэй хэлбэр хийцийн хувьд ижил юм. Мөн оны орчим Монгол-Монакогийн хамтарсан судалгааны төслийн багийн Архангай аймгийн Ихтамир сумын нутаг Хөрөөгийн үзүүрт малтсан 37 дугаартай булш нь оршуулгын зан үйл, он цагийн судалгаагаар Мөнххайрханы соёлд хамаарах нь тогтоогджээ. Тус булш Хөрөөгийн үзүүрийн хадны зураг бүхий нэгэн толгойн энгэрт орших, намхан нэг үе дараас бүхий тэгш өнцөгт хэлбэртэй, 5.7х6.2 м хэмжээтэй булш бөгөөд малтлагын 55 см гүнд их биеийг дээш харуулан хоёр хөлийг өвдгөөр нугалан агийлгаж, зүүн хойд зүгт хандуулан тавьсан оршуулга илэрчээ (Gantulga et al. 2023). Тус булшнаас ямар нэгэн олдвор илэрч олдоогүй аж.

2019 онд Монгол-Японы хамтарсан “Эртний монгол хүн” төслийн судалгааны баг Завхан аймгийн Тосонцэнгэл сумын нутаг Ав далайн хясаа хэмээх газарт Мөнххайрханы соёлд хамаарах 1 булш малтан судалжээ. Тус булш нь 16,8х13,2 м, тэгш өнцөгт дөрвөлжин хэлбэртэй бөгөөд булшнаас тоногдсон хүний оршуулга, хүрэл цагариг ээмэг, модон? халбаганы хугархай хэсэг зэрэг олдвор илэрч олджээ (Amgalantugs et al. 2019; Miyamoto et al. 2023).

2020 онд Увс аймгийн Хяргас сумын нутаг

дахь усан цөөрмийн талбайд хийсэн археологийн авран хамгаалах малтлага судалгааны явцад Мөнххайрханы соёлд хамаарах 1 булш малтан судалсан байна (Enkhtur et al. 2020). Тухайлбал, 3 дугаартай тус булшнаас хүнээ зүүн талаар нь хэвтүүлэн хөлийг өвдгөөр атийлган нугалж, зүүн зүгт хандуулан оршуулсан оршуулга илэрчээ. Оршуулгын хөл хэсгээс хүрэл цагариг 1, хүний далны орчмоос 25 см орчим урттай ясан халбага, бөгтөр мөртэй хүрэл хутга, улаан өнгийн билүү чулуу, хүний толгой дороос давхар гархин хүрэл ээмэг 2, хүзүүний доод талаас 4 ширхэг чулуун зүүлт зэрэг баялаг олдвор хэрэглэгдэхүүн илэрч олджээ (Enkhtur. 2020). Энэ нь Увс аймгийн нутагт анх удаа тус соёлын булшийг илрүүлж малтсан тохиолдол болсон онцлогтой.

2022 онд Монгол-Германы хамтарсан “Баркор” төслийн судалгааны баг Өвөрхангай аймгийн Хужирт сумын нутаг Орхон голын хойд эрэгт орших Хүрдэгийн дэнж хэмээх газар Мөнххайрханы соёлд хамаарч болохуйц нэг булш малтан судалжээ. (Batsukh et al. 2022). Тус булш нь дөрвөлжин хэлбэртэй 7,7 x 7,4 м хэмжээтэй, малтлагаас хүний зарим яснууд, хугархай ясан халбага зэрэг илэрч олджээ (Batsukh et al. 2022, 67, 69). Тухайн булшийг малтан судалсан судлаачид уг булш нь Сагсай хэлбэрийн булшнаас эрс ялгаатай болохыг дурдсан ба булшны нүхний чиглэл, олдвор зэрэг нь Мөнххайрханы соёлд холбогдохыг илтгэнэ. Энэ нь тус соёлын тархцыг ихэд тэлэхийн зэрэгцээ одоогоор мэдэгдээд буй хамгийн зүүн урд захын булш болно.

2024 онд Монгол-Америкийн хамтарсан “Бэлчээрийн мал аж ахуйн археологи төсөл”-ийн судалгааны баг Увс аймгийн Зүүнхангай сумын нутагт ажиллахдаа Хүрдлэгийн аманд Мөнххайрханы соёлын булш 2, Сэрвэн уулын өвөрт буюу хуучин багийн төвийн балгасны хажуугаас 1 булш шинээр илрүүлж, эдгээрээс Хүрдлэгийн амны зэрэгцээ хоёр булшны зүүн талын булшийг сонгон малтаж, хүрэл хутга билүү чулуу, бугын шүдэн зүүлт зэрэг олдвор илрүүлжээ (Bayarsaikhan et al. 2024). Тус судалгааны ангийн үр дүнгээр өмнө нь Увс аймагт бүртгэгдээд байсан Мөнххайрханы соёлын 1 булшийг 4 болгон нэмэгдүүлсэн бөгөөд цаашид ч Увс аймгийн нутаг дэвсгэрээс энэ соёлын булш харьцангуй олон тоотой илэрч олдох магадлалтай байна. Түүнээс гадна Хүрдлэгийн амны ойролцоо буюу Гялгарын өврийн өвөлжөөнд малтсан ZK513 дугаартай бууц суурины малтлагаар 13 соёлт давхарга бүхий эртний хүмүүс амьдарч байсан үл мөрийг илрүүлсэн бөгөөд НТӨ 2026-1881 оны үед холбогдох 12-р давхаргаас адуу, хонь зэрэг амьтдын яс олджээ (Houle et al. 2022). Энэ нь Мөнххайрханы соёлын булш оршуулгын дурсгалыг амьдарч байсан бууц суурины хамт нэг дороос илрүүлэн олсон анхны тохиолдол болох төдийгүй цаашид тухайн соёлын нийгэм, аж ахуйн талаар илүү өргөн хүрээний мэдээлэл авах боломжийг


бүрдүүлж байна.

Ийнхүү дөнгөж 2003 оноос анх судлагдаж эхэлсэн Мөнххайрханы соёлын булшны судалгаа 22 жилийн хугацаанд чамгүй өргөжин тэлж бидний шүүж үзсэн баримтаар малтан судалсан булшны тоо 24 болж тархцын хүрээ тэлж өргөжжээ. Үүний зэрэгцээ малтан судлаагүй ч баттай Мөнххайрханы соёлд холбогдох 6 булшийг бүртгээд байна. Үүнд: Хөвсгөл аймгийн Арбулаг сумын Хийтийн голын 2, Увс аймгийн Өмнөговь сумын Бургатайн голын 1, Зүүнхангай сумын сумын Сэрвэн болон Хүрдлэгийн амны тус бүр нэг 1, Завхан аймгийн Сонгино сумын Айраг нуурын 1 зэрэг нийт 6 булшийг малтлага судалгаа хийгээгүй Мөнххайрханы соёлын булшинд багтааж үзэж болно.

Соёлын тархац. Одоогоор бүртгэгдэж судлагдаад буй Мөнххайрхан соёлын булшийг аймаг тус бүрээр авч үзвэл, Баян-Өлгий аймагт 1, Ховд аймагт 4, Увс аймагт 5 (малтсан 2, малтаагүй 3), Завхан аймагт 6 (малтсан 5, малтаагүй 1), Хөвсгөл аймагт 11 (малтсан 9, малтаагүй 2), Булган аймагт 1, Архангай аймагт 1, Өвөрхангай аймагт 1 нийт 8 аймгийн нутагт 30 булш байгаа болно. Үүнээс харахад Мөнххайрханы соёлын булш нь Монголын баруун, хойд, төв хэсгийн уулархаг болон ойт хэсгийн гол мөрний хөндийг дагаж тархсан харагдана. Булшны тархцын хүрээ өргөн хэмжээний газар нутгийг хамарч байгаа дүр зурагтай харагдаж байгаа хэдий ч тархац нь маш сийрэг одоогоор Мөнххайрханы соёлын булш илэрч олдоод буй нийт 8 аймгийн 4 аймгийн хэмжээнд тус бүр 1 булш бүртгэгджээ. Тиймээс Мөнххайрханы соёлын булш руу чиглэсэн хайгуул судалгааг дагнан хийж гүйцэтгэж соёлын тархац хүрээ, нягтралыг тодорхойлох шаардлагатай юм. Мөн 30 орчим булшны хэрэглэгдэхүүнээр нэг соёлыг төлөөлөн ойлгох нь судалгааны хувьд тун чамлалттай. Учир нь ийм цөөн булшны үр дүн нь тухайн соёлын талаарх ойлголт, мэдээллийг зарим талаар бүрэн өгч чадахгүй байх учир дутагдалтай.

Дашрамд дурдахад Мөнххайрханы соёлд хамаарах 4 булшийг Саяны нуруунаас буюу ОХУ-ын Красноярскийн хязгаарын өмнөд хэсэгт малтан судалсан (Aleksandrov et al. 2015) болохыг А.А.Ковалев тэмдэглэжээ.

Булшны гадаад, дотоод зохион байгуулалт. Мөнххайрхан соёлын булш нь ихэвчлэн газрын хөрснөөс үл ялиг цухуйх хавтгай дараастай байх бөгөөд хэлбэрийн хувьд дөрвөлжин, эсвэл дугуй хэлбэртэй байна. Чулуун дараас нь ихэвчлэн нэг үе байх бол Увс аймгийн Хяргас сумын Билүүгийн голд 2022 онд малтсан тоногдоогүй булшны дараасны захаас бусад хэсэгт 2-3 үе байх онцлог ажиглагдана. Мөн Завхан аймгийн Баянтэс сумын Хөх хошууны боом болон Өвөрхангай аймгийн



Зураг 1. Одоогоор Монгол улсын нутаг дэвсгэрээс илрээд буй Мөнххайрханы соёлын булшны тархац

Хужирт сумын Хүрдэтийн дэнжийн дөрвөлжин хэлбэртэй булш дөрвөн буланд жижиг хөшөө чулуу гозойлгож тавьсан тохиолдол байна. Дараасны төв хэсэг дэх булшны нүхийг том чулуугаар чигжсэн тохиолдол цөөнгүй бөгөөд хүний хажуу болон хөл талаар том чулуу тавьж хашлага хийсэн зэрэг онцлогууд бий. Булшинд хүнээ зүүн зүгт хандуулан хөлийг өвдгөөр дээш нугалан оршуулдаг зан үйлтэй. Одоогоор малтан судалсан 8 булшинд хүнээ хандуулсан чиглэл нь баттай мэдэгдэж буй бөгөөд үүнээс нэг тохиолдолд буюу Завхан аймгийн Тэлмэн сумын Бага шовх улаан хэмээх газарт малтсан булшинд нас барагчийг баруун зүгт хандуулсан хэмээн тодорхойлжээ (Amartuvshin et al. 2017). Энэ нь магадгүй тус булшны тоногдсон байдлаас үүдсэн байхыг үгүйсгэхгүй.

Олдвор, Хүрлийн үеийн бусад соёлын дурсгалтай харьцуулахад Мөнххайрханы соёлын булшинд харьцангуй баялаг олдвор хэрэглэгдэхүүн дагалдуулдаг уламжлалтай. Тэр дундаа яс, хүрлийг сайтар боловсруулж зэр зэвсэг, гоёл чимэглэл хийдэг төдийгүй Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын Шар говийн эхэн хэмээх газарт малтсан булшнаас нэхмэл эдлэл илэрч олдсон (Kovalev and Munkhbayar 2018) нь хүрлийн үеийн дурсгалаас илэрч олдоогүй судалгааны нэн чухал ач холбогдолтой олдвор болно. Хүрэл эдлэлд, хутга, шөвөг, ээмэг, цагариг; харин ясан эдлэлд, халбага, зэв, зүүлт зэрэг зүйлс багтана. Завхан аймгийн Баянтэс сумын Хөх хошууны боомын 1-р булш болон Тэлмэн сумын

Бага шовх улааны булшнаас дөрвөлжин нүхтэй ясан зүүлт олон тоогоор олдсон байхын зэрэгцээ Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Цагаан уушгийн булшнаас танан чимэглэлүүд олджээ.

Харин оршуулгад ваарын холбогдолтой олдвор дагалдуулдаггүй онцлогтой. Нэг тохиолдолд буюу Хогоргын голд малтсан булшны чулуун дараасны завсраас ваарны хагархайнууд илэрч олдсон байдаг ба эдгээр нь тус соёлын дурсгалтай шууд холбогдох эсэхийг одоогоор тодорхойлоогүй байна. Мөн хутгатай хамт билүү чулуу дагалдуулсан тохиолдол хоёр удаа бүртгэгдсэн байна. 2024 онд бидний Увс аймгийн Зүүнхангай сумын Хүрдлэгийн аманд малтсан булшнаас хүрэл хутгыг билүү чулуутай хамт хүний хөлд тавьсан нь хөндөгдөөгүй илэрч олдсон. Харин тус билүүнд хэрэглээний гэх ул мөр ажиглагдаагүй. Мөн тус булшнаас илэрсэн бугын шүдэн зүүлт урьд өмнө малтан судалсан Мөнххайрханы соёлын булшнаас илэрч олдож байгаагүй ч Монгол, Байгаль, Сибирь, Алтайн неолит болон хүрлийн түрүү үеийн соёлын дурсгалуудаас түгээмэл олддог олдвор билээ (Derevyanko and Dorj 1992; Bazaliiskii 2023; Tishkin 2023).

Тахилын байгууламж. Мөнххайрханы соёлын дурсгалд булшнаас гадна олон хөшөө чулуу бүхий тахилын байгууламж багтдаг талаар өгүүлсэн байдаг (Kovalev and Erdenebaatar 2014). Бидний 2024 онд Увс аймгийн Зүүнхангай сумын Хүрдлэгийн амнаас илрүүлсэн Мөнххайрханы соёлын 2 булш

хажуу талдаа мөн жижгэвтэр олон хөшөө бүхий тахилын байгууламжтай байсан билээ. Үүнээс харьцангуй том тэгш өнцөгт хэлбэртэй босгосон хөшөө чулуудтай, дотор талдаа ихэвчлэн нэг талын хананд шахсан мөн тэгш өнцөгт хэлбэр бүхий дараастай, зүүн гадна талд хөшөө бүхий дугуй байгууламжтай тахилын байгууламжийг зарим судлаачид Мөнххайрханы соёлд эсвэл хүрлийн дунд үед холбогдуулах хандлага ажиглагдаж байна (Amartuvshin et al. 2017; Gantulga et al. 2023). Гэвч ийм олон хөшөө бүхий тахилын байгууламж бүрийг нийтээр нь ийнхүү эрт үед холбогдуулж үзэх нь учир дутагдалтай мэт бөгөөд ялангуяа харьцангуй том тэгш өнцөгт хэлбэртэй хөшөө чулууд бүхий тахилын байгууламж нь хүрлийн хожуу үед буюу хиригсүүр, буган хөшөөний соёлын үед бүтээгдсэн байх магадлалтай. Тиймээс эдгээр тахилын байгууламжийн асуудлыг хөндөхдөө тэдгээрийн хэлбэр, бүтэц зохион байгуулалтыг сайтар нягталж, үнэмлэхүй он цагтай харьцуулах нь чухал юм. Мөн ийм тэгш өнцөгт хэлбэртэй хөшөө чулууд бүхий тахилын байгууламж нь Мөнххайрханы булштай харьцуулахад харьцангуй том орон зайд тархсан байх бөгөөд тооны хувьд асар олон байгаа нь эргэлзэх бас нэгэн үндэслэл болж байна.

Ийм төрлийн тахилын байгууламжууд нь түрүү хүрлийн үеийн Цэнгэл хэлбэрийн тахилын байгууламж, хүрлийн түрүү? болон дунд үед хамаарах дөрвөлжин хэлбэр үүсгэсэн хөшөө чулууд, дотроо зууван дугуй дараастай буюу харьцангуй энгийн бүтэцтэй тахилын байгууламж, хүрлийн хожуу үед хамаарах том тэгш өнцөгт хэлбэр үүсгэсэн хөшөө чулууд, дотроо мөн ихэвчлэн тэгш өнцөгт хэлбэрийн хавтгай дараастай тахилын

байгууламж гэсэн он цагийн ерөнхий баримжаа авч болох бөгөөд цаашид үнэмлэхүй он цагийн судалгааны тоог нэмэгдүүлж байж аль хэлбэр нь ямар соёлтой холбогдох эсэх талаар хэлэлцэх нь зүйтэй санагдана.

Дүгнэлт

А.А.Ковалев, Д.Эрдэнэбаатар нарын судлаачид Мөнххайрханы соёлын дурсгалыг анх нээн илрүүлж, 14 булш оршуулгын дурсгалыг 4 аймгийн нутагт малтан судалсан байдаг. Сүүлийн жилүүдэд хийгдсэн археологийн судалгааны үр дүнг нэгтгэн үзвэл өдгөө 8 аймгийн нутагт 30 булш илэрч, малтан судалсан булшны тоо 24 болж өсжээ. Хэдий тийм ч соёлын дурсгалын тархац маш сийрэг одоогоор Мөнххайрханы соёлын булш илэрч олдоод буй нийт 8 аймгийн 4 аймгийн хэмжээнд тус бүр 1 булш бүртгэгдэн малтан судалжээ. Хэрэв Мөнххайрханы соёлын дурсгал руу чиглэсэн зорилтот хайгуул судалгааг хийж гүйцэтгэвэл дурсгалын тоо эрчимтэй нэмэгдэх боломжтой хэмээн бид үзэж байна.

Малтсан булшны тоо нэмэгдэхийн сацуу олдворын тоо, төрөл хэлбэр нэмэгдэж улам баяжиж байна. Тиймээс цаашид хүрэл эдлэл химийн элементийн найрлагыг тодорхойлж бусад үеийн хүрэл эдлэлтэй харьцуулах, ясан эдлэлүүдийг ямар мал амьтны яс ашиглан хийж байсан зэргийг нарийвчлан тодорхойлбол судалгааны сонирхолтой үр дүн гарах боломжтой. Мөн тухайн соёлыг бүтээгч хүмүүсийн антропологи хэв шинж, угсаа гарвал, соёлын залгамж холбоо, аж ахуй, нийгэм соёлын олон талт асуудлыг тусгайлан авч үзэх шаардлагатай байна.

НОМ ЗҮЙ

Александров С.М, Боковенко Н.А, Городилов А.Ю, Лазаретов И.П, Поляков А.В. Охранные работы Саянской археологической экспедиции ИИМК РАН в долине р. Иджим в 2014 г. Бюллетень No. 5. Охранная Археология. Санкт-Петербург 2015.

Амартүвшин Ч, Гүнчинсүрэн Б, Эрдэнэ-Очир Н, Базаргүр Д, Одсүрэн Д, Батдалай Б. Завхан аймгийн Тосонцэнгэл сумаас Сонгино сумын чиглэлд тавигдахаар төлөвлөгдөж буй 150 км урттай авто замын шугамын дагуу хийсэн археологийн авран хамгаалах малтлага судалгааны ажлын тайлан. ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн ГБСХ. Улаанбаатар 2017.

Амгалантөгс Ц, Мияamoto К, Базаргүр Дашзэвэг, Дэлгэрмаа Лхагвасүрэн. Монгол-Японы хамтарсан “Эртний монгол хүн” төслийн 2019 оны хээрийн шинжилгээний ангийн товч үр дүн. // *Монголын археологи-2019*. Улаанбаатар, 2019, т. 226-232.

Батсүх Д, Цэлхагарав Ц, Броседдер У, Гантулга Ж. Монгол-Германы “Баркор” “Barkhor” төслийн 2022 оны судалгааны ажлын товч үр дүн. // *Монголын археологи-2022*. Улаанбаатар 2022, т. 66–71.

Баярсайхан Ж. Умард Монголын нутагт малтан судсан хүрлийн үеийн нэгэн булш. // *Нүүдэлчдийн өв судлал*. Tomus. XV, Fasc. 3. Улаанбаатар 2013, т. 22–28.

Баярсайхан Ж, Түвшинжаргал Т, Баяндэлгэр Ч, Кларк Ж, Тэйлор В. Монгол-Америкийн хамтарсан “Умард Монгол” төслийн 2017 оны хээрийн судалгааны ажлын тайлан. Монголын Үндэсний музейн номын сан. Улаанбаатар 2017.

Баярсайхан Ж, Хюль Ж, Түвшинжаргал Т, Экүүз Н, Конеса Ф, Буян-Орших Б, Бямбадорж Б. Монгол-Америкийн хамтарсан “Бэлчээрийн мал аж ахуйн археологи” төслийн хээрийн судалгааны ажлын тайлан. ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн ГБСХ. Улаанбаатар 2024.

Базалийский В.И. Археология в городской среде. Могильник локомотив. Иркутск, Оттиск 2023.

Идэрхангай Т, Мижиддорж Э, Оргилбаяр С, Галбадрах Б, Эрдэнэ Ж, Өнөрбаяр Б, Энхмагнай Г. Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Эгийн голын усан цахилгаан станцын усан сангийн талбайд явуулсан археологийн авран хамгаалах малтлага судалгааны ажлын 2025 оны тайлан. Улаанбаатарын Их Сургууль. Улаанбаатар 2015.

Тишкин А.А (Ред). Алтайн түүх. Нэн эрт, эрт, дундад зууны үе. Соёмбо Принтинг. Улаанбаатар 2023.

Энхтөр А, Болорбат Ц, Батболд Г, Алдармөнх П, Буянхишиг Ц. Увс аймгийн Хяргас сумын

нутаг Билүүгийн голд барьж буй хөв цөөрмийн 1,800,000 m³ багтаамжтай усан сангийн газарт орж буй археологийн дурсгалуудыг авран хамгаалах судалгаа: Археологийн авран хамгаалах малтлага судалгааны тайлан. ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн ГБСХ. Улаанбаатар, 2020.

Эрдэнэбаатар Д, Ковалев А. Мөнххайрханы соёл. // *Studia Historica*. Tomus XXXIV, Fasc 1. Улаанбаатар 2003, т. 8–13.

Эрдэнэбаатар Д, Ковалев А. Монгол Алтайн бүс нутгийн археологийн соёлууд. *Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology*, Vol.3, 1(287). Улаанбаатар 2007, т. 35–50.

Эрдэнэбаатар Д, Ковалев А. Мөнххайрханы соёлын булш. // Монголын эртний булш оршуулга. III Боть. Эрхлэн хэвлүүлсэн Г.Эрэгзэн. Улаанбаатар 2016, т. 46–57.

Ковалев А.А, Эрдэнэбаатар Д. Открытие в центре Евразии новой культуры эпохи развитой бронзы (Мунх-Хайрханская культура). Российский археологический ежегодник. – No. 4. – СПб.: Университетский издательский издательский консорциум, 2014, стр. 194–225.

Ковалев А.А. Мунх-Хайрханская культура периода развитой бронзы и ее связи с культурами неолита – бронзового века восточной сибир. *Актуальные вопросы арххеологии и этнологии центральной Азии. Матерналы II международной научной конференции* (г. Улан-Удэ, 4-6 декабря 2017 г). Редакторы, Б.В Базаров. Издательство БНЦ СО РАНЬ. Улан-Удэ. 2017, стр. 57–66.

Ковалев А.А, Мунхбаяр Ч. Раскопки уникального погребально-ритуального комплекса Мунх-хайрханской культуры Шар говийн эхэн 1 в высокогорном районе Монгольского Алтая. // *Известия лабарратории древних технологий*. Том 14, No. 3, 2018, стр. 43–58. DOI, <http://dx.doi.org/10.21285/2415-8739-2018-3-43-58>

Derevyanko A.P, and Dorj D. “Neolithic Tribes in Northern Parts of Central Asia.” In *History of Civilizations of Central Asia*, I, 169–89. UNESCO publishing, 1992.

Kovalev Alexey A, Erdenebaatar Diimaajav. Discovery of New Cultures of the Bronze Age in Mongolia according to the Data Obtained by the International Center Asian Archaeology Expedition. In *Current Archaeological Research in Mongolia 4*, Papers from the First International Conference on “Archaeological Research in Mongolia” held in Ulaanbaatar, August 19th–23rd, 2007, edited by Jan Bemmann Hermann Parzinger, Ernst Pohl, and Damdinsüren Tseveendorzh, pp. 149–170. Vor- und Frühgeschichtliche Archäologie Rheinische Friedrich-Wilhelms-Universität, Bonn. 2009.

Houle, Jean-Luc, Oula Seitsonen, Natalia Égüez, Lee G. Broderick, Juan José García-Granero, and

Jamsranjav Bayarsaikhan. 2022. "Resilient Herders, A Deeply Stratified Multiperiod Habitation Site in Northwestern Mongolia." *Archaeological Research in Asia* 30 (June), 100371. <https://doi.org/10.1016/j.ara.2022.100371>.

Miyamoto, Kazuo, Tatsuro Adachi, Tsend Amgalantugs, Natsag Batbold, Dashzeveg Bazargur, Lhagvadorj Delgermaa, Masahiro Fukunaga, et al. 2023. "Excavations at Avdalai Khyasaa Site, The Fourth Report on Joint Mongolian-Japanese Excavations in Outer Mongolia." Department of Archaeology, Faculty of Humanities, Kyushu University. <https://doi.org/10.15017/7160669>.

REFERENCES

Aleksandrov S.V, Bokovenko N.A, Gorodilov A.Yu, Lazaretov I.P, Polyakov A.V. *Okhrannye raboty Sayanskoy arkheologicheskoy ekspeditsii IIMK RAN v doline r. Idzhim v 2014 g. [Rescue research of the Sayan Archaeological Expedition of the IHMC, RAS in the Idzhim River valley in 2014]*. Bulletin Institute for the History of Material Culture of the Russian Academy of Sciences (Rescue Archaeology). – No. 5. – St. Petersburg, Nevskaya Book Printing House Publishing, 2015, 250 pages.

Amartuvshin Chunag, Gunchinsuren Byambaa, Erdene-Ochir Nasan-Ochir, Bazargur Dashzeveg, Odsuren Davaakhuu, Batdalai Byambatseren. *Zavkhan aimgiin Tosontsengel sumaas Songino sumyn chigleld tavigdakhaar tuluvlugduj bui 150 km urttai auto zamyn shugamyn daguu khiisen Arkheologiiin avran khamgaalakh maltlaga sudalgaany ajlyn tailan [Report on the Archaeological Rescue Excavations Conducted along the Route of the Planned 150 km Long Road from Tosontsengel Sum to Songino Sum, Zavkhan Province]*. Ulaanbaatar 2017. Institute of Archaeology, Mongolian Academy of Sciences.

Amgalantugs Tsend, Miyamoto K, Bazargur Dashzeveg, Delgermaa Lkhagvasuren. Mongol-Yapony khamtarsan "Ertny mongol khun" töslin 2019 ony kheeriin shinjilgeenii angiiin tovch ür dün [Preliminary Results of the 2019 Fieldwork Conducted by the Mongolian-Japanese Joint Project "Ancient Mongolian People"]. *Mongolian Archaeology-2019*. Ulaanbaatar, 2019, pages 226–232.

Batsukh Dunburee, Tselkhagarav Tsogbayar, Ursula Brosedder, Gantulga Jamyan-Ombo. Mongol-Germani "Barkor" töslin 2022 ony sudalgaany ajlyn tovch ür dün [Preliminary Results of the 2022 Research for the Mongol-German "Barkhor" Project]. *Mongolian Archaeology-2022*. Ulaanbaatar, 2022, pages 66–71.

Bayarsaihan Jamsranjav. Umard Mongolyn nutagt maltan sudalsan khürlyn uyeiin negen bulsh [The Bronze Age Grave of the Northern Mongolia]. *Nomadic Heritage Studies*. Vol. XV, Fasc. 3. Ulaanbaatar, 2013, pp. 22–28.

Bayarsaikhan Jamsranjav, Tuvshinjargal Tumurbaatar, Bayandelger Chinbold, Julia Clark William Taylor. *Mongol-Amerikiin khamtrsan "Umard Mongol" töslin 2017 ony kheeriin sudalgaany ajlyn tailan [Report on the 2017 Field Research of the Mongolian-American "Northern Mongolia" Project]*. Ulaanbaatar, 2017. National Museum of Mongolia.

Bayarsaikhan Jamsranjav, Jean-luc Houle, Tuvshinjargal Tumurbaatar, Natalia Ėgüez, Francesc C. Conesa, Buyan-Orshikh Baasandorj, Byambadorj Batsuren. *Mongol-Amerikiin khamtarsan "Belcheeriin mal aj akhuin arkheologi" töslin kheeriin sudalgaany ajlyn tailan [Report on the Field Research of the Mongolian-American Joint Project "Mongolian Pastoralist Archaeologies]*. Ulaanbaatar, 2024. Institute of Archaeology, Mongolian Academy of Sciences.

Bazaliyskiy, V.I. *Arkheologiya v gorodskoy srede. Mogilnik Lokomotiv [Archaeology in the Urban Environment. The Locomotive Burial Site]*. Irkutsk, Ottisk 2023.

Derevyanko, A.P, and D Dorj. "Neolithic Tribes in Northern Parts of Central Asia." In *History of Civilizations of Central Asia*, I, 169–89. UNESCO publishing, 1992.

Enkhtur Altangerel, Bolorbat Tserendorj, Batbold Gonchig, Aldarmunkh Purev, Buyankhishig Tserenkhand. *Uvs aimgiin Khyargas sumyn nutag Biluugiin gold barij bui khöv tsöörmiin 1,800,000 m³ bagtaamjtai usan sangyn gazart orj bui arkheologiiin dursgaluudyg avran khamgaalakh sudalga, Arkheologyn avran khamgaalakh maltlaga sudalgaany tailan [Rescue Research of Archaeological monuments Located in the Area of the 1,800,000 m³ Reservoir Being Constructed at Biluu River in Khyargas Soum, Uvs Aimag, Archaeological Rescue Excavation Report]*. Ulaanbaatar, 2020. Institute of Archaeology, Mongolian Academy of Sciences

Erdenebaatar, Diimaajav, and Kovalev Alexey. Munkhkhairkhan soyol [The Munkhkhairkhan Culture]. *Studia Historica* XXXIV (1), (2003): 8–13.

Erdenebaatar Diimaajav, Kovalev Alexey. Mongol Altain büs nutgiin arkheologiiin soyoluud [Archaeological Cultures of the Mongolian Altai Region]. *Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology*, Vol.3, 1(287). Ulaanbaatar, 2007, pp. 35–50.

Erdenebaatar Diimaajav, Kovalev Alexey. Graves of the Munkhkhairkhan culture. In *Ancient Burial Practices of Mongolia*. Mongolian Archaeological Heritage. Vol. 3. Institute of the History and Archaeology. Editor, G. Eregzen. Ulaanbaatar, 2016, pp. 46–57.

Houle, Jean-Luc, Oula Seitsonen, Natalia Ėgüez, Lee G. Broderick, Juan José García-Granero, and Jamsranjav Bayarsaikhan. 2022. "Resilient Herders, A Deeply Stratified Multiperiod Habitation Site in Northwestern Mongolia." *Archaeological Research in Asia* 30 (June), 100371. <https://doi.org/10.1016/j.ara.2022.100371>.

ara. 2022.100371.

Iderkhangai Tumr-Ochir, Mijiddorj Enkhbayar, Orgilbayar Samdantsodol, Galbadrakh Baatar, Erdene Jargalsaikhan, Unurbayar Bekh-ochir, Enkhmagnai Ganbaatar. *Bulgan aimgiin Khutag-Undur sumyn nutag Egiin golyn usan tsakhilgaan stantsiin usan sangiin talbaaid yavuulsan arkheologiin avran khamgaalakh maltlaga sudalgaany ajlyn 2015 ony tailan [2015 Report on the Archaeological Rescue Excavations Conducted in the Reservoir Area of the Eg River Hydroelectric Power Station, Khutag-Undur Soum, Bulgan Aimag]*. Ulaanbaatar University. Ulaanbaatar 2015.

Kovalev Alexey A, Erdenebaatar Diimaajav. Discovery of New Cultures of the Bronze Age in Mongolia according to the Data Obtained by the International Center Asian Archaeology Expedition. In *Current Archaeological Research in Mongolia 4*, Papers from the First International Conference on "Archaeological Research in Mongolia" held in Ulaanbaatar, August 19th–23rd, 2007, edited by Jan Bemmman Hermann Parzinger, Ernst Pohl, and Damdinsüren Tseveendorzh, pp. 149–170. Vor- und Frühgeschichtliche Archäologie Rheinische Friedrich-Wilhelms-Universität, Bonn. 2009.

Kovalev Alexey, Erdenebaatar Diimaajav. Discovery of a new Bronze Age culture in Central Eurasia (Munkh-khairkhan culture). *Russian Archaeological Annual*. – No. 4. – St. Petersburg, University Publishing Consortium, 2014, pp. 194–225.

Kovalev Alexey. Munkh-Khairkhan culture of the Bronze Age and its connections with Neolithic-Bronze Age Cultures of Eastern Siberia. Actual problems of Archaeology and ethnology of Central Asia. *Mate-*

rials of the II International Conference (Ulan-Ude, December 4–6th, 2017). Editors, B.V. Bazarov, N.N. Kradin. Ulan-Ude, The Buryat Scientific Center SB RA. 2017, pp. 57–66.

Kovalev Alexey and Munkhbayar Chuluunbat. Excavation of Unique burial-ritual complex Shar Goviin Ekhen of the Munkh-Khairkhan culture in highlands of the Mongolian Altai. // *Journal of Ancient Technology Laboratory*. Vol. 14, No. 3, 2018, pp. 43–58. DOI, <http://dx.doi.org/10.21285/2415-8739-2018-3-43-58>


Miyamoto, Kazuo, Tatsuro Adachi, Tsend Amgalantugs, Natsag Batbold, Dashzeveg Bazargur, Lhagvadorj Delgermaa, Masahiro Fukunaga, et al. 2023. "Excavations at Avdalai Khyasaa Site, The Fourth Report on Joint Mongolian-Japanese Excavations in Outer Mongolia." Department of Archaeology, Faculty of Humanities, Kyushu University. <https://doi.org/10.15017/7160669>.

Tishkin, A.A (ed). *Altain tiiikh. Nen ert, ert, dundad zuuny üye [The History of Altai, Prehistoric, Ancient, and Medieval Periods]*. Ulaanbaatar, 2023.




Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial.

See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>



Зураг 2. Увс аймгийн Зүүнхангай сумын Хүрдлэгийн аманд малтсан Мөнххайрханы 1-р булины дэвсгэр болон хөндлөн зүсэлтийн зураг (@Баярсайхан нар 2024)



Зураг 3. Увс аймгийн Зүүнхангай сумын Хүрдлэгийн амны Мөнххайрханы 1-р булинаас илэрсэн олдворууд. 1 – Шүдэн зүүлт, 2 – Хүрэл хутга, 3 – Билүү чулуу

Хүснэгт 1. Малтлага судалгаа хийсэн Мөнххайрханы соёлын булины мэдээлэл

№	Аймаг, сум	Газрын нэр дурсгалын дугаар	Хэлбэр, хэмжээ	Хүний байрлал	Хандуулсан зүг	Олдворын тухай мэдээлэл	Малтсан судлаачид, он
1	Ховд Мөнххайрхан	Улаан говийн үзүүр. Булш 1/1	Дугуй, Голч 3,2 м	Зүүн хажуугаар нь хэвтүүлэн хөлийг атийлгаж тавьсан.	Зүүн	Ясан халбага, хүрэл хутга, модон бариултай хүрэл шөвөг, модон савх	Ковалев, Эрдэнэбаатар, 2003
2	Ховд Мөнххайрхан	Улаан говийн үзүүр. Булш 2/1	Дугуй	Тоногдсон. Хөлийг атийлгаж тавьсан.	-	Олдвор илэрч олдоогүй.	Ковалев, Эрдэнэбаатар, 2003
3	Ховд Мөнххайрхан	Хатуу даваа 1/1, Хөх толгой	Дугуй	Тоногдсон	-	Махир хэлбэртэй хүрэл эдлэл	Ковалев, Эрдэнэбаатар, 2003
4	Ховд Мөнххайрхан	Артау	Дугуй	Тоногдсон. Цээжийг дээш харуулан, хөлийг нугалсан	?	Олдвор илэрч олдоогүй.	Ковалев, Эрдэнэбаатар, 2003
5	Хөвсгөл, Арбулаг	Галбаагийн үзүүр Булш 1/1	Дугуй, Голч 30 м	Тоногдсон. Хүний яс илэрсэн	-	-	Ковалев, Эрдэнэбаатар, 2006
6	Хөвсгөл, Арбулаг	Галбаагийн үзүүр Булш 1/2	Дөрвөлжин 6х6 м	Зүүн хажуугаар нь	Зүүн хойд	Хүрэл хутга, хүрэл шөвөг	Ковалев, Эрдэнэбаатар, 2006
7	Хөвсгөл, Бүрэнтогтох	Цагаан уушиг 2	Дөрвөлжин 3х3 м	Тоногдсон. Хүний эрүүний яс олдсон	-	-	Ковалев, Эрдэнэбаатар, 2006
8	Хөвсгөл, Бүрэнтогтох	Цагаан уушиг 3	Дөрвөлжин 6х6 м	Тоногдсон. Өсвөр насны хүүхдийн яс олдсон	-	Дугуй хэлбэртэй танан чимэглэлүүд (бүтэн 20, хагархай 10)	Ковалев, Эрдэнэбаатар, 2006
9	Завхан, Баянтэс	Хөх хошууны боом 1/1	Дөрвөлжин 5х5 м	Тоногдоогүй?	-	Ясан зүүлт	Ковалев, Эрдэнэбаатар, 2007
10	Завхан, Баянтэс	Хөх хошууны боом 4/1	Дугуй	?	-	С а л а а с у р в а л ж т а й ясан зэвүүд?	Ковалев, Эрдэнэбаатар, 2007
11	Завхан, Баянтэс	Хөх хошууны боом	Дугуй	?	-	-	Ковалев, Эрдэнэбаатар, 2007
12	Хөвсгөл, Цагааннуур	Хогоргын гол	Дугуй, 5,5 м	Зүүн хажуугаар нь хөлийг атийлгаж тавьсан.	Зүүн урд 110°-т	Оршуулгад дагалдуулж тавьсан олдвор илрээгүй ч чулуун дараасны завсраас ваарын хагархайнууд олдсон.	Баярсайхан, 2007

13	Баян-Өлгий, Цэнгэл	Шар говийн эхэн	Дугуй, Голч 43 м	Тоногдсон оршуулга	-	Ясан халбага, тааран эдлэл дээр сураар бэхэлсэн хүрэл цагариг	Ковалев, Мөнхбаяр 2014
14	Архангай, Их тамир	Хөрөөгийн үзүүр Булш 37	Дугуй, 6,2 м	Их биеийг дээш харуулж, хөлийг баруун хажуугаар нь атийлгаж тавьсан.	Зүүн хойд 20°-т	Олдвор хэрэглэгдэхүүн илэрч олдоогүй.	Гантулга нар ?
15	Булган, Хутаг өндөр	Харуулын гозгор 1-113	Дугуй, Голч 9 м	Зүүн хажуугаар нь хөлийг атийлгаж тавьсан.	Зүүн хойд 53°-т	Ясан халбага, хүрэл хутга, хүрэл цагариг 3, хүрэл шөвөг, ясан болцуу	Идэрхангай нар, 2015
16	Хөвсгөл, Улаан- Уул	Багсагийн булан Булш 1	Дугуй, Голч 3,7 м	Хүний яс илрээгүй	-	Олдвор эд өлгийн зүйлс илэрч олдоогүй.	Баярсайхан нар, 2017
17	Хөвсгөл, Улаан- Уул	Багсагийн булан Булш 2	Дөрвөлжин 3,2х3,2 м	Хүний эрүүний хугархай	-	Хүрэл цагариган ээмэг	Баярсайхан нар, 2017
18	Завхан, Тэлмэн	Бага шовх улаан 3-р булш	Дугуй, Голч 3,2 м	Тоногдсон	Баруун?	Дөрвөлжин хэлбэртэй эвэр (ясан) зүүлт 40 ш, хүрэл зүү	Амартүвшин нар, 2017
19	Завхан, Тосонцэнгэл	Ав далайн хясаа Булш 15	Тэгш өнцөгт дөрвөлжин, 16,8 х 13,2 м	Тоногдсон	-	Хүрэл цагариг ээмэг, модон? халбаганы хугархай хэсэг	Амгалантөгс, Miyamoto 2019
20	Увс, Хяргас	Билүүгийн гол Дурсгал 3	Дугуй, Голч 4 м	Зүүн хажуугаар нь хөлийг атийлгаж тавьсан.	Зүүн	Ясан халбага, хүрэл хутга, улаан өнгийн билүү чулуу, давхар цагариган хүрэл ээмэг, хүрэл зүү, чулуун зүүлт	Энхтөр нар, 2020
21	Өвөрхангай, Хужирт	Хүрдэтийн дэнж. OOR 232, feat 131	Дөрвөлжин, 7,7 х 7,4 м	Тоногдсон	Зүүн хойд	Ясан халбаганы хугархай	Батсүх нар, 2022
22	Увс, Зүүнхангай	Хүрдлэгийн ам. Булш 1	Дугуй, Голч 8,3 м	Тоногдсон	Зүүн	Хүрэл хутга, билүү чулуу, бугын шүдэн нүхтэй зүүлт	Баярсайхан нар, 2024